



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 112

Мандалговь

Орон сууц хувьчлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Орон сууц хувьчлах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Өндөршил сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 38,200,680 /гучин хоёр сая хоёр зуун мянга зургаан зуун ная/ төгрөгийн балансын үнэтэй, 18,463,662 /арван найман сая дөрвөн зуун жаран гурван мянга зургаан зуун жаран хоёр/ төгрөгийн үлдэгдэл өртөгтэй орон нутгийн өмчийн 4 айлын орон сууцыг одоо эзэмшиж байгаа иргэнд нь хавсралтын дагуу тогтоосон үнээр хувьчилсугай.

Хоёр: Орон сууц хувьчлах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг дарга бөгөөд Орон сууц хувьчлах товчооны дарга (О.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



С.СҮХБААТАР

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2019 оны ... дугаар сарын  
... өдрийн ... тогтоолын хавсралт

Хувьчлах орон сууцнуудын жагсаалт

№	Эзэмшигчийн нэр	Барилгын байршил	Хөрөнгийн нэр	Байгуулагын нэр	Хэмжээ	Ашиглалтанд орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан эзлэгдэл	Үлгэдэл өртөг	Худалдах үнэ
1	Т.Отгондулам	Өндөршил сум	4 айлын орон сууц	ЗДП	240 м2	1987	38,200,680	19,737,018	18,463,662	1,000,000
2	Т.Багбилэг									1,000,000
3	Д.Уранбилэг									1,000,000
4	М.Баярмаа									1,000,000